



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/451
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НЭГДСЭН ЗАХИРГАА” ААТҮГ -ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

*YAG –ын Санхүүгийн Аудитын Газрын
Дарга: Ц.Наранчимэг
Утас: 263533*

*Аудитын менежер : Я.Самбууням
Утас: 260512*

Аудитор: Ж.Болормаа

*Аудитор : “Координат Аудит” ХХК
Гүйцэтгэх захирал - П.Баярмаа
Утас : 99193732*

АУДИТЫН ТАЙЛАН

2016 оны Санхүүгийн тайлангийн аудит

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Монгол улсын

Үндэсний аудитын газар

Хаяг : Засгийн газрын IV байр,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу – 6,
Улаанбаатар – 46, Монгол улс

Вэб хуудас: www.mnao.pmis.gov.mn

Хэвлэсэн огноо :
2017 оны 02 –р сарын 15

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Материаллаг байдлын түвшин
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын дүгнэлт

АУДИТ ХИЙХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

“Төрийн аудитын тухай хууль” -ийн 15.1.2 –т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 –д заасны дагуу Монгол улсын Ерөнхий аудитор 2013 оны 9 дүгээр сарын 5 –ны өдрийн 158 дугаар тушаалаар “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх журам” –ыг баталсан.

“Төрийн аудитын тухай хууль” -ийн 18 дугаар зүйлийн 18.2 дугаарт заасан Төрийн аудитын байгууллагын эрх үүрэг болон Ерөнхий аудиторын баталсан дээрх журмын дагуу Монгол улсын Ерөнхий аудитор А.Зангадын баталж, олгосон 2016 оны 10 дугаар сарын 06 –ны өдрийн 14 тоот эрхийн бичиг бүхий зөвшөөрлөөр, “Төсвийн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.9.8 –д заасан цаглабарын дагуу “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ын 2016 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх аудитын ажлыг “Координат Аудит” ХХК гүйцэтгэж, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар хяналт тавина.

Аудитыг Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ын 2016 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, бодлого, журам” –ын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн менежер нь байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага нь тухайн байгууллагын санхүүгийн тайлангууд нь тус байгууллагын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн эсэх талаар санал дүгнэлтээ илэрхийлэх үүрэгтэй.

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын ажлыг 2016 оны 11 дүгээр сарын 02 –ны өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 26 –ны өдрийн хооронд гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу "Координат Аудит" ХХК –ийн аудитын баг гүйцэтгэв.

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 13 –ны өдөр "Координат Аудит" ХХК –д ирүүлсэн байна.

“Координат Аудит” ХХК жилийн эцсийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25 –ны өдрөөс 2017 оны 2 дүгээр сарын 25–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15 –ны өдөр “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ын удирдлагад гардуулна.

БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Төсвийн тухай хууль”, “Нягтлан болох бүртгэлийн тухай хууль”, “Архивын тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд “Нягтлан болох бүртгэлийн тухай хууль” шинэчлэгдэн 2016 оны 1 сарын 1 –нээс эхлэн мөрдөгдөж эхэлсэн. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам” Сангийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 8 –ны өдрийн 131 дүгээр тушаалаар батлагдан, мөрдөгдөж эхэлсэн. Эдгээрээс бусад хууль, тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

“ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” Монгол улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 149 дугаар тогтоолоор Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын харьяа Засгийн газрын байруудын нэгдсэн захиргааг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд ажиллуулах, үйл ажиллагааны дүрмийг баталж мөрдүүлэхээр Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт үүрэг болгосон.

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын эрхэм зорилго нь Төрийн үйлчилгээний чанарыг эрхэмлэн хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн шуурхай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Тус байгууллага нь 3 алба, 191 ажилтантайгаар ажиллаж, Засгийн газрын 8 байрны 12,357.0 м.кв талбай бүхий, нийтийн эзэмшлийн 26,810.8 м.кв талбай бүхий 847 албан тасалгаа, 1890 гаруй ажилтан, албан хаагчдад дараах 16 төрлийн нийтлэг үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Үүнд: Цахилгаан, дулаан, ус хангамж, сантехник, барилгын засвар, мужаан, цэвэрлэгээ, лифт, цай визит, цайны газар, угаалга, ариутгал, цэцэгт ногоон байгууламж, харуул хамгаалалт, угтах үйлчилгээнүүд, өмч хөрөнгийн ашиглалт, хангамж, заал, танхим, автогражийн үйлчилгээ, гэрээ, түрээс, санхүүгийн үйлчилгээнүүд хамаарна.

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын 2016 онд улсын төсөвт болон хувийн хэвшлийн байгууллагуудаас ажил үйлчилгээ гүйцэтгэх тухай гэрээ, түрээсийн гэрээнүүдийн дагуу олсон орлогоор санхүүжсэн байна.

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ХЯНАЛТЫН СОРИЛ БОЛОН НАРИЙВЧИЛСАН ГОРИМ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Санхүүгийн тайлангийн аудитын ажлыг гүйцэтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын 2016 оны тайлант жилийн санхүүгийн тайлангууд нь тус байгууллагын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авах зорилгоор дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 39 -г гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 онд боловсруулан 2014 оны тайлант жил дуустал мөрдөж ажилласан байна. Тус байгууллага Засгийн газрын 2014 оны 149 –р тогтоолын дагуу 2015 оны 01 дүгээр сарын 01 –ээс эхлэн аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар болсонтой холбогдуулан өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулсан НБББББ –ийг боловсруулахаар төлөвлөсөн ч, хийгдээгүй байв.

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Интер Актив” ХХК –ийн Даймонд санхүүгийн программыг ашиглан, санхүүгийн тайлангаа бэлтгэн гаргасан байна.

Энэхүү программ болон компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулгаар болон биет горим хэрэгжүүлэн танилцаж, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул программаас гарсан мэдээллийг боловсруулан аудитын ажлыг гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс хяналтын сорилыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр гүйцэтгэсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй

ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын дотоод хяналтын үйл ажиллагааны уламжлалт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хийсэн сорилоор хэвийн гэж тогтоосон.

ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ нь 2016 оны тайлант жилд үндсэн үйл ажиллагааны орлогоороо өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж, үндсэн үйл ажиллагааны орлогоор 3309.0 мянган төгрөгийн орлого олж, 3467,0 сая төгрөгийн зардалтай ажиллан, 158,8 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилго бүхий “Шилэн дансны тухай хууль” –ийг хэрэгжүүлэхэд тодорхой ажил хийгдээгүй.

Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn –д хуулинд заагдсан мэдээллүүдийг оруулдаг боловч Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй. Худалдан авалтын талаарх мэдээллийг хуулинд заасан хугацаанд нь, үнэн зөв оруулаагүй байв. Жишээ нь : Цэвэрлэгээний материал болон бараа материал худалдан авалтын мэдээллийг зарим саруудад дутуу оруулсан нь Шилэн дансны тухай хуулийн “6.4. улсын өмчит үйлдвэрийн газар байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.3. тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” гэж заасныг мөрдөөгүй байна.

МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Байгууллагын үйл ажиллагааны онцлог болон нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг судлан, шинжилсний үндсэн дээр тус байгууллагын 2016 оны тайлант жилийн санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх

материаллаг байдлын түвшинг “Орлогын дэлгэрэнгүй тайлан” дахь Ерөнхий ба удирдлагын зардлын 1% -иар тооцож, 36,0 сая төгрөгөөр тогтоолоо.

ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу 9 эрсдлийг тогтоож батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс тус бүрээр нийт 39 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Горим сорилыг гүйцэтгэх явцад дараах тодорхойлсон үр дагаврууд гарав. Үүнд:

- Тус байгууллага анх 2009 онд 1,542,477.0 мянган төгрөгийн төрийн өмчтэйгөөр үүсгэн байгуулагдсан ба 2016 оны санхүүгийн байдлын тайланд төрийн өмчийн эцсийн үлдэгдэл нь 4,435,228.8 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна. 2009-2016 онуудад нэмэгдсэн хөрөнгийг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгаагүй байна.
- 2016 оны тайлант жилд машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд нийт 58,069.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас хөргөгчийг 4; 5 ба 10 жилээр, принтерийг 4 ба 5 жилээр, компьютерийг 4; 5 ба 20 жилээр гэх мэт нийт 45,932.0 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийн ашиглах хугацааг ижил төрлийн хөрөнгөнд өөр өөрөөр тооцсон байна. Хөрөнгийн ашиглах буруу байгуулснаар элэгдлийн зардал үнэн зөв гарахгүй үр дүнд нөлөөлж байна. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа санхүүгийн мэдээллийн системд оруулсан элэгдэл байгуулах хугацаагаар тооцоход 2016 оны тайлант жилд нийтдээ 11,634,871.2 мянган төгрөгийн хөрөнгөнд 3-10 сарын хугацааны элэгдэл байгуулсан байснаас 102,971.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцоолсон байсныг тайлант оны эцэст залруулсан.

ГОЛ, ОНЦЛОХ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, үйл ажиллагааны орлого, цалин хөлс, элэгдэл, харуул хамгаалалтын зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорилоор тайлант хугацаанд гарсан 6,139 ажил гүйлгээ буюу нийт ажил гүйлгээний 48.2 хувийг аудитын түүвэрт ашиглав. Хяналтын сорилоор эдгээрийн 3,816 гүйлгээ буюу нийт дүнгийн 62.2 хувийг, түүвэр шалгалтаар үлдсэн гүйлгээ буюу 2,323 гүйлгээг шалгаж үзэв.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад данс тус бүрээр материаллаг хэмжээний алдаа илрээгүй.

Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

2016 оны тайлант жилд нийт 98,583.0 мянган төгрөгийн бараа материал худалдаж авсан ба түүнээс 129,439.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж тайлант үеийн зардлаар тайлагнасан байна.

Бараа материалыг орлого болгох болон зарлага болгохдоо бараа материалыг хүлээж авсан болон зарлага болгосон анхан шатны баримтыг бүрэн зөв үйлддэггүй, баримтын бүрдэл дутуу байна. Үүнд : Бэлтгэн нийлүүлэгчээс хүлээн авсан бараа материалын орлогын баримт үйлддэггүй. Бараа материалыг зарлага болгох зөвшөөрлийг хариуцсан нягтлан бодогчоос авдаггүй. Бараа материалын зарлагын баримт үйлдэлгүй, шаардах хуудсаар шууд зарлага болгодог гэх мэт.

Дээрх байдал нь бараа материалын худалдан авалт болон зарцуулалтанд тавих хяналт сул байгааг илэрхийлж байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгөгдсөн.

АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10 -ны өдрийн 149 дүгээр тогтоолоор Засгийн газрын байруудын нэгдсэн захиргааг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд ажиллуулах, үйл ажиллагааны дүрмийг баталж мөрдүүлэхээр заасан бөгөөд байгууллагын дүрмийн төслийг боловсруулсан боловч, батлагдаагүй байлаа.

“Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай” Монгол улсын Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 09 ний өдрийн 135 тоот тогтоолоор “Төрийн үйлчилгээ” ААТҮГ, “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ыг нийлүүлэн, “Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” ААТҮГ болгон өөрчлөн байгуулахаар тогтоосон байна.

Их хэмжээний авлага үүссэн талаар :

Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа ААТҮГ нь төсвийн байгууллагууд болон түрээслэгч хувь хүн, компаниудад байр түрээслэх үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд 25,8 сая төгрөгийн түрээсийн авлага оны эцэст үлдсэнээс 25,0 сая төгрөгийн авлага нь Зам тээврийн хөгжлийн яамнаас авах түрээсийн авлага байна. Үлдсэн 0.8 сая төгрөгийн авлага нь хувь хүн, аж ахуй нэгжээс авах авлага байна.

Хөрөнгийн тооллого чанаргүй хийдэг талаар :

Үндсэн хөрөнгийн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулахад Ерөнхий нягтлан бодогч оролцдоггүй бөгөөд тооллого хийх ажиллагаа чанаргүй хийгдэж байв. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 –д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.” гэж заасныг дагаж мөрдөхийг зөвлөсөн болно.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй талаар:

Тус байгууллага нь 2015 оны 1 дүгээр сарын 1 –ний өдрөөс аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болсон ба 2015-2016 онуудын тайлант жилд төсвийн байгууллагын статустай байхдаа ашиглаж байсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөж ажиллана.” 20.2.2 – т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүргийг ерөнхий нягтлан бодогч хүлээнэ.” гэсэн шаардлагыг хангахгүй байна.

ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй үлдсэн бусад алдаа байхгүй.

ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал нь бараа материалын бүртгэл байлаа. Иймээс бараа материалтай холбоотой зарцуулалтын анхан шатны баримтын иж бүрдэл болон үндсэн хөрөнгийн бүртгэл, тооллого, хяналтыг дараагийн аудитаар хянаж үзэх шаардлагатай.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 102.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, залруулав.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Төсвийн менежерийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Үндэсний аудитын газар” –аас өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд албан шаардлага болон аудитын зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг 2016 оны 5 дугаар сарын 26 -ны өдрийн 145 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлжээ.

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Санал дүгнэлтийн үндэслэл

Бидний хийсэн аудитаар санхүүгийн тайланд нөлөөлж болох материаллаг байдлын түвшинг 36.0 сая төгрөгөөр тогтоосон ба аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлын мөнгөн дүн нь 102.9 сая төгрөг байсныг тайлант хугацаанд нь залруулан, тайлагнасан тул зөрчилгүй санал дүгнэлт өгөхийг санал болгож байна.

“Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад тус байгууллагын уг өдрөөрх санхүүгийн байдал хийгээд уг өдрөөр тасалбар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, заавар журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.



“ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НЭГДСЭН ЗАХИРГАА” ААТҮГ -ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Үндэсний Аудитын Газрын -
Санхүүгийн Аудитын Газрын

Дарга: Ц.Наранчимэг
Утас: 263533

Аудитын менежер : Я.Самбууням
Утас: 260512

Аудитор: Ж.Болормаа

“Координат Аудит” ХХК –ийн
Гүйцэтгэх захирал : П.Баярмаа
Мобайл : 99193732

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

2016 оны Санхүүгийн тайлангийн аудит

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1 Төрийн өмчийн бүртгэл,
тайлагналын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2 Үндсэн хөрөнгийн элэгдлийн
тооцооллын талаар

Асуудал 3 Нийгмийн даатгалын тайлагнал

Асуудал 4 Бараа материалын анхан шатны
баримтын бүрдэл, түүний хяналт

Монгол Улсын Үндэсний Аудитын Газар

Хаяг :Засгийн газрын IV байр,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу – 6,
Улаанбаатар – 46, Монгол улс

Вэб хуудас : www.mnao.pmis.gov.mn

Хэвлэсэн огноо :

2017 оны 01 –р сарын 30

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар санхүүгийн тайлангийн аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн энэхүү менежментийн захидлыг “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд дотоод хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС –ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимыг хэрэгжүүлэх явцад гарсан ба бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлтээ гаргахад зориулагдсан болно.

Энэ нь “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь хөндлөнгийн хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага нь энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор санал болгож байгаа бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа” ААТҮГ –ын холбогдох ажилтнуудад талархлаа илэрхийлье.

Тэргүүлэх ач холбогдол №1: Цаашид санхүүгийн тайланд (энэ оных биш) шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул нэн даруй анхаарвал зохих асуудлууд;

Тэргүүлэх ач холбогдол №2: Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд; ба

Тэргүүлэх ач холбогдол №3: Аудитын явцад бидний ажигласан бөгөөд цаашид аудитын санал дүгнэлтэд нөлөөлөх магадлалгүй асуудлууд.

Асуудал 1 Төрийн өмчийн бүртгэл, тайлагналын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
<u>Ажиглалт:</u> Тус байгууллагын эзэмшиж буй төрийн өмчийн дүн нь байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 1,54 тэрбум төгрөгийн мөнгөн дүнтэй, харин Санхүүгийн байдлын тайланд 4,45 тэрбум төгрөгийн мөнгөн дүнтэй тусгасаар байна.	<u>Зөвлөмж:</u> Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж, үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт гарсан тухай бүрд Засгийн газрын тогтоолыг үндэслэн улсын бүртгэлд бүртгүүлэх. Төрийн өмчийн бүртгэлийг эрх зүйн баримт бичигт үнэн бодитоор тусгадаг байх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллах.
<u>Эрсдэлүүд:</u> Төрийн өмчийг холбогдох эрх зүйн баримт бичигт үнэн зөв бүртгэхгүйгээс үүдэн буруу ташаа мэдээлэгдэх, өмч хөрөнгийг хяналтаас гадуур ашиглах нөхцөл бололцоог бий болгоно.	<u>Төсвийн менежерийн хариу:</u> Байгууллагын дүрэм өөрчлөгдөн ирээгүй байгаа бөгөөд 2016 оны эцэст манай байгууллага татан буугдаж шинээр зохион байгуулагдаж байна.

Асуудал 2 Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>Ажиглалт</u> Тус байгууллага нь 2016 оны 12 дугаар сарын 31 -ний байдлаар нийт 19,312.2 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгөтэй байсан ба түүний 2.16% -ийг 417.4 сая төгрөгийн өртөг бүхий машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил эзэлж байгаа болно. 2016 оны тайлант жилд машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд нийт 58,1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан ба элэгдэл байгуулах ашиглалтын хугацааг нэг төрлийн хөрөнгөнд өөр өөрөөр авч тооцсон байна. Тус байгууллагын тайлант жилийн зардалд эзлэх үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нь цалингийн зардлыг хассан дүнгийн 20.0 % -ийг эзэлдэг болно.	<u>Зөвлөмж</u> НББОУС 16 – “Үндсэн хөрөнгө” –д “Үндсэн хөрөнгийн зүйлийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: (а) хөрөнгөд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай; ба (б) хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой.” гэсэн шаардлагыг хангаж бүртгэл хөтлөх. Мөн тус стандартаар : - Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг, түүнийг бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд, ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. - Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилна. - Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой ба хэрэв өмнө тооцоолсноос өөрчлөгдөнө гэсэн төсөөлөл байвал өөрчлөлтийг НББОУС 8 Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа -нд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж бүртгэнэ. гэсэн шаардлагыг хангаж, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодорхойлж, үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоолох коэффициент, ашиглах жилийг үндсэн хөрөнгийн ангилал, нэр төрөл бүрээр нь бодитойгоор тодорхойлон, тайлант үеүдэд тогтвортой мөрдөх.
<u>Эрсдэлүүд</u> Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан бодитой бус тайлагнагдах. Үндсэн хөрөнгөнд тавих хяналт хэрэгжихгүй байх.	<u>Төсвийн менежерийн хариу:</u> Элэгдэл буруу байгуулагдсан байсныг санхүүгийн тайланд залруулсан. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана:

Асуудал 3 Бараа материалын анхан шатны баримтын бүрдэл, түүний хяналт	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>Ажиглалт</u> 2016 оны тайлант жилд нийт 151,7 сая төгрөгийн бараа материалын зардал гарсан ба энэ нь тус байгууллагын тайлант жилийн нийт зардлаас цалингийн зардлыг хассан дүнгийн 7.7 % -ийг эзэлж байна. Анхан шатны баримтын бүрдэл дутуу. Үүнд : Бэлтгэн нийлүүлэгчээс хүлээн авсан бараа материалын орлогын баримт үйлддэггүй. Бараа материалыг зарлага болгох зөвшөөрлийг хариуцсан нягтлан бодогчоос авдаггүй. Бараа материалын зарлагын баримт үйлдэлгүй, шаардах хуудсаар шууд зарлага болгодог гэх мэт.	<u>Зөвлөмж</u> Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах. Тус хуулийн "13 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт" – д: "13.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасныг хэрэгжүүлэх.
<u>Эрсдэлүүд</u> Бараа материалд тавих хяналт хэрэгжихгүй байх, зүй бусаар ашиглах.	<u>Төсвийн менежерийн хариу:</u> Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Асуудал 4 Нийгмийн даатгалын тайлагнал	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>Ажиглалт</u> 2016 оны тайлант жилд нийт 310.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын өглөгийн тооцоо үүссэн бөгөөд тухайн сарын цалингийн хүснэгтээр бодогдсон цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг тухайн сард нь тайлагнадаггүй. Нэг сарын цалинг 1-3 хувааж тайлагнадаг. Нийт 7 хүний 29.3 сая төгрөгийн цалинг нийгмийн даатгалд хувааж зөрүүлж тайлагнасан нь тухайн сарын нийгмийн даатгалын зардал зөв тусгагдахгүй байна.	<u>Зөвлөмж</u> Нийгмийн даатгалын тухай хуулийн 16.1 – д : “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлэх.
<u>Эрсдэлүүд</u> Хугацаандаа тайлагнаж, төлөөгүй НДШ –д торгууль, алданги ноогдох. Тайлант хугацааны зардал алдаатай тайлагнагдах.	<u>Төсвийн менежерийн хариу:</u> Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

"ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НЭГДСЭН ЗАХИРГАА" ААТҮГ
2016 оны 12 -р сарын 31 -ээрх жилийн санхүүгийн тайлан

СТ-1

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)		
ҮЗҮҮЛЭЛТ	01 -р сарын 01	12 -р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,580,552	144,788,985
Дансны авлага		25,806,483
Бараа материал	394,662,114	363,172,216
Эргэлтийн хөрөнгийн дүн	403,242,666	533,767,684
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4,103,709,550	3,940,347,984
Биет бус хөрөнгө	10,489,926	7,379,365
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,114,199,476	3,947,727,349
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,517,442,142	4,481,895,033
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Татварын өглөг	588,347	
Урьдчилж орсон орлого	5,905,550	46,266,251
Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,493,897	46,266,251
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	6,493,897	46,266,251
ЭЗДИЙН ӨМЧ		
Өмч : - төрийн	6,564,099,041	4,435,228,782
Хуримтлагдсан ашиг	(2,053,150,796)	
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,510,948,245	4,435,228,782
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,517,442,142	4,481,895,033

"ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НЭГДСЭН ЗАХИРГАА" ААТҮГ
2016 оны 12 -р сарын 31 -ээрх жилийн санхүүгийн тайлан

СТ-2

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)		
ҮЗҮҮЛЭЛТ	2015 онд	2016 онд
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	3,054,121,381	3,309,001,818
Борлуулалтын өртөг		
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	3,054,121,381	3,309,001,818
Бусад орлого	54,636,687	149,894,431
	54,636,687	149,894,431
Ерөнхий ба удирдлагын зардал	3,399,444,305	3,597,861,587
Бусад зардал	19,088,172	19,599,929
	3,418,532,476	(158,565,267)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(4,468,794)	(255,267)
	(4,468,794)	(255,267)
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	(314,243,201)	(158,820,534)
Орлогын татварын зардал		
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	(314,243,201)	(158,820,534)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(314,243,201)	(158,820,534)
ОРЛОГЫН НИЙТ ДҮН	(314,243,201)	(158,820,534)
НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ/АЛДАГДАЛ)		

"ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НЭГДСЭН ЗАХИРГАА" ААТҮГ
2016 оны 12 -р сарын 31 -ээрх жилийн санхүүгийн тайлан

СТ-3

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Дахин үнэлгээний зөрүү	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2014 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	6,564,099,041	0	(1,276,528,542)	5,287,570,499
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				0
Залруулсан үлдэгдэл	6,564,099,041	0	(1,276,528,542)	5,287,570,499
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(314,243,201)	(314,243,201)
Бусад дэлгэрэнгүй орлого				0
Өмчид гарсан өөрчлөлт	(462,379,053)			(462,379,053)
2015 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	6,101,719,988	0	(1,590,771,743)	4,510,948,245
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	6,101,719,988	0	(1,590,771,743)	4,510,948,245
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(158,820,534)	(158,820,534)
Бусад дэлгэрэнгүй орлого		83,101,072		83,101,072
Өмчид гарсан өөрчлөлт	(1,666,491,205)	(83,101,072)	1,749,592,277	
2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	4,435,228,783	0	0	4,435,228,783

"ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НЭГДСЭН ЗАХИРГАА" ААТҮГ
2016 оны 12 -р сарын 31 -ээрх жилийн санхүүгийн тайлан

СТ-4

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Түншийн тайлангаарх дүн	
	2015 онд	2016 онд
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	3,078,151,376	3,516,419,831
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,076,584,678	3,514,312,131
Бусад мөнгөн орлого	1,566,698	2,107,700
Мөнгөн зарлагын дүн (-)	3,069,570,824	3,380,211,398
Ажиллагсдад төлсөн	1,165,357,626	1,226,222,090
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	293,524,962	311,659,687
Бараа материал худалдан авахад төлсөн	362,063,600	1,338,239,824
Ашиглалтын зардалд төлсөн	686,792,573	1,718,344
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	295,830,655	174,412,142
Татварын байгууллагад төлсөн	111,769,765	118,981,691
Бусад мөнгөн зарлага	154,231,643	
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,580,552	136,208,433
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	8,580,552	136,208,433
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(8,580,552)	8,580,552
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	144,788,985